

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 67.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн захиргааны удирдлагын бүтцийг дараахь байдлаар тогтоосугай.
 - 1.1. Засаг дарга;
 - 1.2. Засаг даргын орлогч (хоёроос илүүгүй);
 - 1.3. Засаг даргын Тамгын газрын дарга.
2. Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:
 - 2.1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвтэй);
 - 2.2. Хууль, эрх зүйн хэлтэс (архивын тасагтай);
 - 2.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс;
 - 2.4. Санхүү, төрийн сангийн хэлтэс;
 - 2.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
 - 2.6. Нийгмийн бодлогын хэлтэс;
 - 2.7. Цэргийн штаб.
3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 46 хүртэл, Булган, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрыг 42 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 34 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай.
4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан агентлаг ажиллуулахаар тогтоосугай:
 - 4.1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар;
 - 4.2. Биеийн тамир, спортын газар;
 - 4.3. Боловсрол, шинжлэх ухааны газар;
 - 4.4. Гаалийн алба;
 - 4.5. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
 - 4.6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
 - 4.7. Мал эмнэлгийн газар;
 - 4.8. Мэргэжлийн хяналтын газар;
 - 4.9. Нийгмийн даатгалын хэлтэс;
 - 4.10. Онцгой байдлын газар (хэлтэс);
 - 4.11. Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагааны албатай);
 - 4.12. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба;
 - 4.13. Соёл, урлагийн газар;
 - 4.14. Стандарт, хэмжил зүйн хэлтэс;
 - 4.15. Статистикийн хэлтэс;
 - 4.16. Татварын хэлтэс;
 - 4.17. Улсын бүртгэлийн хэлтэс;
 - 4.18. Ус, цаг уур, орчны шинжилгээний төв;